

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН  
САНГИЙН ХЭЛТСИЙН 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2019 оны 6-р сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

**1.1 Монгол улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн биеэ даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана.**

**1.1.1 Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, орон нутгийн төсвийн биеэ даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулж, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ил тод, нээлттэй байдлыг ханган, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ.**

**Хэрэгжилт, биелэлт:**

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2018 оны ээлжит зургадугаар хуралдаанаар хэлэлцэн батлагдсан 2019 оны төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг хийж, дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг даргаар батлуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажилласнаар Дүүргийн төсвийн орлогын 6-р сарын төлөвлөгөөний биелэлтийг 2018 оны 6-р сарын 31-ний өдрийн байдлаар авч үзвэл: Улсын төсөвт 4 684.3 сая төгрөг төвлөрөхөөс 2 201.8 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 47.0%-ийн, Нийслэлийн төсөвт 5 936.9 сая төгрөг төвлөрөхөөс 861.1 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 14,5%-ийн, Орон нутгийн төсөвт 5 612.9 сая төгрөг төвлөрөхөөс 1 890.7 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 33.7 %-ийн, **өссөн дүнгээр төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл** Улсын төсвийн орлого 101.6%-аар, Нийслэлийн төсвийн орлого 80.1%-аар, Орон нутгийн төсвийн орлого 70.0%-аар тус тус биелэлттэй гарч, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн биелэлтийг хангахад хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож, орлогоороо зарлагаа нөхөн биеэ даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

**Хүрч буй үр дүн: Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, орлогоороо зарлагаа нөхөн биеэ даан ажиллах нөхцлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.**

**1.1.2 Төсвийн урсгал зардалд дүн шинжилгээ хийж, зардал бууруулах, төсвийн сахилга хариуцлага, дүүргийн төсвийн байгууллагуудын орлого, зарлага, хөрөнгө оруулалтын ажил болон хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.**

**Хэрэгжилт, биелэлт:**

Батлагдсан төсвийн хуваарийн дагуу Орон нутгийн болон Тусгай зориулалтын шилжүүлгийн 2019 оны 2-р улирлын санхүүжилтийн эрхийг

өссөн дүнгээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад 8 906.3 сая төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн байгууллагуудад 12 024.8 сая төгрөг, хөдөлмөр халамжийн байгууллагуудад 104.6 сая төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 1 295.0 сая төгрөгийг тус тус олгож, гүйцэтгэлд хяналт тавьж, үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах боломжийг ханган ажилласан.

**Хүрч буй үр дүн: Төсвийн үргүй зардлыг бууруулах бодлогыг баримтлан ажилласнаар төсвийн урсгал зардлыг 0,3 хувиар хэмнэсэн.**

**1.1.3 Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний уялдааг хангах ажлын зураг төсөв, техникийн тодорхойлолтуудыг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэн бэлэн болгож, Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлж, тендер шалгаруулалтыг зохион байгуулна.**

**Хэрэгжилт, биелэлт:**

Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, О.Н.Х. сангаас хийгдэх “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” дүүргийн Засаг даргын 2019 оны А/02, А/12 дугаар захирамжуудын төслийг тус тус боловсруулан баталгаажуулж, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, зохион байгуулах ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Нийслэлээс эрх нь шилжин ирсэн О.Н.Х сангийн хөрөнгө оруулалтын ажлуудын “Үнэлгээний хороо” байгуулах дүүргийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулан хянуулж, баталгаажуулан хэрэгжилтэд нь хяналт тавин тендерийн сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийн гэрээ хийх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эхлүүлэх, санхүүжилтийн урьдчилгаа олгох бэлтгэл ажлуудыг зохион байгуулж, гүйцэтгэл явцад нь хяналт тавин ажилласан байна.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын 9, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 30 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын зураг, тоо хэмжээг холбогдох хэлтэс, албадаас гаргуулан авч хянан, дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд тус тус хүргүүлж ажилласан байна.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 9 төсөл арга хэмжээ хэрэгжихээс гэрээ байгуулагдсан 4, тендерийн баримт бичиг боловсруулагдаж байгаа 1, тендер зарлагдсан байхгүй, эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээ байхгүй, бэлтгэл ажил хийгдэж байгаа 4 төсөл арга хэмжээ тус тус байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 30 төсөл арга хэмжээ хэрэгжихээс гэрээ байгуулагдан ажил нь хийгдэж байгаа төсөл, арга хэмжээ 6, тендерийн шатандаа байгаа 8, бэлтгэл ажил хийгдэж байгаа 13, ажил нь 100% хийгдэж дууссан 3 төсөл арга хэмжээ тус тус байна.

Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн 26 төсөл арга хэмжээ хэрэгжихээс тендерийн үнэлгээ хийгдэж байгаа 10, тендер зарлагдаж материал хүлээн авч байгаа байхгүй, бэлтгэл ажил хийгдэж байгаа 15, гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байхгүй, гэрээ байгуулах шатандаа байгаа 1 төсөл арга хэмжээ тус тус байна.

Он дамжин хэрэгжиж буй 26 төсөл, арга хэмжээнээс тендерийн шатандаа байгаа 10, бэлтгэл ажил хийгдэж байгаа 15, гэрээ байгуулах шатандаа байгаа 1 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын хүрээнд нийт 7 922 471,0 мянган төгрөгийн 84 ажил 100%-ийн гүйцэтгэлтэй гарч байна. Үүнд: Ажлын зураг төсөв, техникийн тодорхойлолт хийгдэж байгаа 5 446 493,2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 25 ажил 30.8%-ийн гүйцэтгэлтэй, Тендер зарласан материал хүлээж авч байгаа 1 345 750,8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 17 ажил 20.9%-ийн гүйцэтгэлтэй, тендерийн нээлт хийгдэж, үнэлгээ хийгдэж байгаа 103 226,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ажил 5.0 %-ийн гүйцэтгэлтэй, шалгарсан оролцогчид гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлсэн 332 155,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ажил 8.7%-ийн гүйцэтгэлтэй, гэрээ байгуулагдан хөрөнгө оруулалтын ажил хийгдэж байгаа 299 963,5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ажил 13.6%-ийн гүйцэтгэлтэй, гэрээ байгуулагдан хөрөнгө оруулалтын ажил нь хийгдэж дууссан 369 882,5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ажил 19.7%-ийн гүйцэтгэлтэй, худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг шилжүүлсэн 25 000,0 мянган төгрөгийн 1 ажил 1.3%-ийн гүйцэтгэлтэй тус тус гарсан байна.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, О.Н.Х.С-ийн хөрөнгө оруулалтын ажлын явцыг авч үзвэл: Мэдээллийн нэгдсэн төвийн доторх интерьэр тохижилт болон доторх цахилгааны ажлын гүйцэтгэлд 55.6 сая төгрөг, Гадна барилгын нэмэлт өргөтгөл, засвар, тавилга, эд хогшил нийлүүлэх ажлын гүйцэтгэлд 23.7 сая төгрөг, Инженерийн шугам сүлжээ, дотор халаалт болон цэвэр бохир усны шугамын ажлын гүйцэтгэлд 8.0 сая төгрөг, Иргэд, хүүхэд залуучууд, ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заалны туг хийх ажлын гүйцэтгэлд 2.7 сая төгрөг, Олон улсын байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, орон нутгийн оролцоог дэмжих, ажилгүй иргэдийг ажлын байраар хангах, материаллаг баазыг нэмэгдүүлэх, багаж тоног төхөөрөмжөөр хангах ажилд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 10.0 сая төгрөгийг тус тус санхүүжүүлсэн бөгөөд төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээнээс нийт 100.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон байна.

**Хүрч буй үр дүн: Хөрөнгө оруулалтын ажил төлөвлөгдсөн хэмжээндээ үе шаттайгаар хэрэгжиж байна.**

**2.1 Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төсвийн захирагч, санхүү бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах чиглэлээр сургалт семинар зохион байгуулах, мэдээллээр хангах.**

**2.1.1 Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төсвийн захирагч, санхүү бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах чиглэлээр сургалт, семинар зохион байгуулах, мэдээллээр хангах.**

#### **Хэрэгжилт, биелэлт:**

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн ажилтан нарын мэдлэг боловсролыг системтэйгээр дээшлүүлэх сургалтын 2019 оны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар батлуулан ажилласнаар:

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын 52 нягтлан бодогч нарт “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах, эрхийн үнэлэх болон үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлж, санхүүгийн тайланд тусгах” сэдэвт сургалтыг 2019 оны 01-р сарын 03-ний өдөр зохион байгуулсан байна.

Монгол улсын Сангийн Яамны Төрийн сангийн газар, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн хамтарсан “Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөж буй заавар, журамд өөрчлөлтийн оруулах талаарх”

хэлэлцүүлэг, семинарт хөтөлбөрийн дагуу хэлтсийн ажилтан нар бүрэн хамрагдаж, өөрчлөлт оруулах санал, төслийг хүргүүлэн ажилласан байна.

**Хүрч буй үр дүн:** Сургалт, семинарыг төлөвлөгөөний дагуу үе шаттай зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан ба боловсон хүчнийг мэргэжлийн арга зүйгээр хангах, тэдний мэдлэгийг дээшлүүлэх ажлын эхлэл тавигдсан.

**2.1.2 Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журмын дагуу дүүргийн цахим хуудас, сурталчилгааны булангаар дамжуулан санхүү, төрийн сангийн үйл ажиллагааг иргэдэд мэдээлэх, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлан, мэдээг олон нийтэд ил тодоор мэдээлэх ажилд хяналт тавин ажиллах.**

**Хэрэгжилт, биелэлт:**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 5 дугаар зүйлийн 5.5, 5.7, 5.8, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор хэлтсийн ажилтнуудын “Шилэн дансны хууль”-ийг хэрэгжүүлэх ажил үүргийн нэгдсэн хуваарийг Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны А/21 дүгээр тушаалаар батлуулан, хуваарийн дагуу мэдээллийг Сангийн Яамны нэгдсэн вэб сайтад оруулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

Чингэлтэй дүүргийн “Шилэн дансны мэдээлэл” самбарын доторх тоон болон график, диаграммын хүснэгтэн мэдээллийг сар бүр сольж, иргэд, олон нийтэд мэдээллийн ил тод, нээлттэй, ойлгомжтой, хүртээмжтэй байдлыг хангаж, иргэд, олон нийтийн мэдээллийн сурталчилгааг ханган ажиллаж байна.

Хэлтсийн 2018 онд зохион байгуулсан ажлын мэдээллийг дүүргийн вэб сайтад тавьж, иргэд олон нийтийг мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг ханган ажиллаж ирлээ.

Мөн дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн 75 төсөвт байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарын өргөтгөсөн семинарыг Дотоод аудитын албатай хамтран 2018 оны 3 дугаар сард зохион байгуулан хийж, “Төсөвт байгууллагуудын 2017 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн шалгалтын дүн, цаашид анхаарах асуудал”-ыг хэлэлцүүлэн, тодорхой үүрэг чиглэлээр ханган ажилласан байна.

Дүүргийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн вэб сайтад цаг хугацаанд нь үнэн зөв оруулах, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулахад дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын алба, Санхүү, төрийн сангийн хэлтсийн 1 мэргэжилтэн нар хариуцан хяналт тавьж, хуулийн шаардлага хангаагүй 6 байгууллагад “Ажил сайжруулах тухай” албан шаардлагыг хүргүүлэн, биелэлтийг ханган ажиллаж байна.

**Хүрч буй үр дүн:** Хуулийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд нь хангаж, иргэд олон нийтэд мэдээллийн ил тод, нээлттэй, ойлгомжтой, хүртээмжтэй байдлыг хүргэж ажилласан.

**2.1.3 Төсөвт байгууллагын төсвийн сахилга батыг сайжруулан, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, урсгал зардлыг бууруулах.**

**Хэрэгжилт, биелэлт:**

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2018 оны ээлжит хуралдаанаар хэлэлцэн батлагдсан 2019 оны төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг хийж, дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг даргаар батлуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажилласнаар нийт зарлага санхүүжилтийн гүйцэтгэл 45 тэрбум 546,2 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэл 34 тэрбум 154,9 сая төгрөгд хүрч, үүнээс: Орон нутаг 25 тэрбум 281,5 сая.төгрөг батлагдсанаас 16 тэрбум 249,2 сая төгрөгт, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын багц 19 тэрбум 162,4 сая төгрөг батлагдсанаас 16 тэрбум 803,5 сая төгрөгт, Эрүүл мэнд, спортын сайдын багц 1 тэрбум 102,2 сая төгрөг батлагдсанаас 1 тэрбум 102,2 сая төгрөгд тус тус хүрч, батлагдсан заавар, журам, тогтоолын дагуу үндсэн баримт нэг бүрээр хянан санхүүжилтийг олгож, хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг төлөвлөсөн хэмжээнд олгож ажилласан байна.

**Хүрч буй үр дүн: Төсвийн үргүй зардлыг бууруулах бодлогыг баримтлан ажилласнаар төсвийн урсгал зардлыг 0,2%-аар хэмнэсэн ба хөрөнгө оруулалтын ажил төлөвлөгдсөн хэмжээндээ явагдаж байна.**

**3.1 Дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээг хянан хүлээн авч, дүнг нэгтгэх, Дүүргийн орон нутгийн төсвийн орлого, төрийн сангийн орлого, зарлага, өр авлагын дэлгэрэнгүй мэдээг гарган дээд шатны төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь хүргүүлэх, гүйцэтгэлд нь дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцох, удирдлагуудыг мэдээллээр хангах.**

#### **Хэрэгжилт, биелэл:**

Дүүргийн төсөвтэй харилцагч орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн зарлагын шифр мэдээг хянан хүлээн авч нэгтгэн, дүүргийн орон нутгийн төсвийн орлого, төрийн сангийн орлого, нэгдсэн зарлага, өр авлагын дэлгэрэнгүй мэдээ, төрийн сангийн орлого, зарлагын сарын нэгдсэн тэнцлийг тус тус гарган, мэдээний тодруулга, тайлбарын хамт дээд шатны төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь хүргүүлж, дүүргийн удирдлагуудыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулан ажиллаа.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, Нийслэлийн засаг даргын “Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны А/43, дүүргийн Засаг даргын “Төсвийн хэрэгжилтийг хангах тухай” 2018 оны А/13 дугаар захирамж, төсөв, санхүүгийн хууль тогтоомж, заавар, журмын хэрэгжилтийн хүрээнд хугацаатай мэдээ тайланг хоцроох, төвийн шууд зардлын өр авлага гаргасан төсвийн шууд захирагч нарын буруутай албан тушаалтанд зохих арга хэмжээ авах асуудлыг зохион байгуулан хэрэгжүүлж ажилласнаар нийт тусгай зориулалтын шилжүүлгийн 3 байгууллагад Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын “Ажил сайжруулах, хариуцлага тооцох, арга хэмжээ авах тухай” албан бичгийг хүргүүлснээр хариуцлагын асуудал хуулийн хүрээнд үндсэн нэгж дээр хэрэгжиж байна.

**Хүрч буй үр дүн: Дүүргийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаанд бүрэн хүлээн авдаг болсон ба төсвийн орлого, зарлагын тэнцлийг цаг хугацаанд гаргаж, үр дүнгээр нь дүгнэлт гаргаж, удирдлагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна.**

**3.1.1 Төрийн сан банкны байгууллагуудын дансны нэгдсэн хуулга, хяналтын төвшин, орлого, зарлагын нэгдсэн данс, журналын тухайн өдрийн гүйлгээг тулган шалгаж баталгаажуулах, нэгдсэн тайланг гарган**

**төрийн сангийн нэгдсэн мемориалыг бэлтгэн хэлтсийн удирдлагад танилцуулж, архивын нэгж болгон ажиллах.**

**Хэрэгжилт, биелэлт:**

Төрийн сан банкны нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй данснуудаар тайлант оны 6-р сарын 14-ний өдрийн байдлаар орлогын хуулгаар 77 184 374 387 төгрөг 79 мөнгөний, нягтлан бодох бүртгэлийн мемориалийн, журналаар зарлагын 13795 ширхэг баримтаар 69 830 285 712 төгрөг 88 мөнгөний гүйлгээг тухай бүрд нь өдрийн гүйлгээгээр тулган шалгаж, төлбөрийн гадаад, дотоод гүйлгээг банк хооронд заавар журмын дагуу хөнгөн шуурхай гүйцэтгэн баталгаажуулж, нэгдсэн тайланг цаг хугацаанд нь гарган, нэг мемориалаар архивын нэгж баримт болгон хянуулж, баталгаажуулан ажиллаа.

Төрийн сангийн банкны төлбөр тооцооны ажлаар төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний системд бүртгэсэн гүйлгээг төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн шалган баталгаажуулах, гүйлгээ залруулахтай холбогдсон залруулгын бичилт, төрийн сан банкны данснуудын үлдэгдэл, орлого, зарлагын дансны хуулга, нягтлан бодох журналаар төрийн сангийн өдөр тутмын гүйлгээг тулган шалгаж нэгдсэн тайланг гарган төрийн сангийн мемориалын баримтыг бэлтгэн хэлтсийн даргаар баталгаажуулан архивын нэгж үүсгэх, төрийн санд нээгдсэн дансны хяналтыг хэрэгжүүлэх, зөвшөөрөлгүй нээгдсэн данснуудыг хаах, дүүргийн З.Г.С.У.М.С-ийн хэрэглэгчийн болон тэмдгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулан гүйцэтгэж ажиллаа.

**Хүрч буй үр дүн: Төрийн сан банкны өдөр тутмын үйл ажиллагаа тогтмолжиж, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай үйлчилж, төлбөр тооцооны үйл ажиллагаа хэвийн, “бага” эрсдэлтэй ажиллаж байна.**

**3.1.2 Дүүргийн Орон нутгийн болон Тусгай зориулалтын шилжүүлгийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан тэнцлийг гаргаж, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулж баталгаажуулах, Санхүүгийн нэгтгэсэн тайлан тэнцлийг Нийслэлийн Аудитын газарт өргөн барьж, хуулийн дагуу санхүүгийн тайлангийн аудит хийлгэн дүгнэлт, зөвлөмж гаргуулах ажлыг зохион байгуулан хийх.**

**Хэрэгжилт, биелэлт:**

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлан тэнцлийг хуваарийн дагуу хянан хүлээн авч баталгаажуулан, санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн аудитыг төсвийн байгууллагуудад хийлгэх, Сангийн Яаманд төсвийн байгууллагын тайланг “Э-ТАЙЛАН”-гаар шивэх, илгээх, баталгаажуулах, Н.Ө.Х.Г-т хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг программаар шивж баталгаажуулах ажлуудыг зохион байгуулан гүйцэтгэн ажиллаа.

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг төсөвт 57 байгууллагаас хүлээн авч хянан гүйцэтгэл 100,0%- тай байгаа ба хянагдсан орон нутгийн 7, тусгай зориулалтын шилжүүлгийн 50, нийт 57 төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангуудыг Нийслэл дэх төрийн аудитын газарт хүргүүлж, санхүүгийн тайлангийн аудит хийлгэх ажлыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулж, нийт байгууллагууд 100.0% нь санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй санал, дүгнэлт” авсан байна. Мөн дүүргийн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн нэгтгэсэн санхүүгийн тайлан тэнцлийг гаргаж, хуулийн дагуу Нийслэл дэх Төрийн аудитын газарт хуулийн хугацаанд санхүүгийн тайлангийн аудит хийлгэхээр өргөн барьж ажилласан байна.

Мөн Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн дүүргийн Төсвийн гүйцэтгэлийн Санхүүгийн нэгтгэсэн тайлан тэнцлийг гаргаж, хуулийн дагуу Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанаас нь өмнө хүргүүлж хянуулах ажлыг зохион байгуулж, мөн Нийслэлийн Аудитын газарт өргөн барьж санхүүгийн тайлангийн аудит хийлгэх ажлыг зохион байгуулан ажилласнаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах аудит”-ын менежментийн захидлыг Дүүргийн Засаг даргад Нийслэлийн аудитын газраас ирүүлж, Захидлын хариуг хүргүүлэн, дүүргийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд “Зөрчилгүй стандарт тайлан” санал дүгнэлт авч ажилласан байна.

**Хүрч буй үр дүн: “Санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах аудит”-ын менежментийн захидлыг дүүргийн Засаг даргад НАГ-аас ирүүлж, Захидлын хариуг хүргүүлэн, “Зөрчилгүй стандарт тайлан” санал дүгнэлт авч ажилласан байна.**

**3.1.3 Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудын улирал, жилийн санхүүгийн тайланг хянан хүлээн авах, е-балансын программаар баталгаажуулж, илгээх, дүн мэдээг нэгтгэх, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах.**

#### **Хэрэгжилт, биелэлт:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай шинэчлэн найруулсан хууль, Монгол улсын Сангийн Сайдын 2014 оны 201 дугаар тушаал, 2016 оны 41 дүгээр тушаалуудын дагуу дүүргийн баазад бүртгэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын болон холбогдох заавар журмын дагуу шалган, илэрсэн зөрчлийг арилгуулан хүлээн авч нэгтгэн, е-балансын программаар баталгаажуулан илгээх ажлыг зохион байгуулан гүйцэтгэж ажиллаа. Санхүүгийн тайлан тэнцэл тушаавал зохих 10987 аж ахуйн нэгж байгууллагаас баталгаажуулсан 8638 аж ахуйн нэгж байгууллага буюу 78.6%, баталгаажуулаагүй 277 аж ахуйн нэгж байгууллага буюу 2.5%, огт ирүүлээгүй 2072 аж ахуйн нэгж байгууллага буюу 18.9%-тай тус тус байна. Тушаасан 10987 аж ахуйн нэгж байгууллагаас хугацаандаа тушаасан 5861 аж ахуйн нэгж, хугацаа хоцроосон 2420 аж ахуйн нэгж байгууллагууд байгаа бөгөөд Санхүүгийн тайлан хүлээн авалт 78.6%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна. Тайлангаа хугацаандаа тушаагүй болон НББ-ийн хууль зөрчсөн 10 албан тушаалтан болон байгууллагад 8 064,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, торгуулийг бүрэн барагдуулан ажиллаж ирлээ.

**Хүрч буй үр дүн: Аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан хуулийн хугацаандаа ирж баталгаажиж, дүн нэгтгэлд орох ажил бүрэн хийгдсэн ба тайлан хүлээн авалт 78.6%-д хүрсэн байна.**

#### **3.1.4 Бодлогын зорилтын зохицуулалтын үр дүнгийн талаар**

##### **Хэрэгжилт, биелэлт:**

Дүүргийн орон нутгийн төсөвт байгууллагуудын 2019 оны төсвийн сар, улирлын хуваарийг хийж, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг даргаар батлуулан үндсэн нэгжид хүргүүлэн ажилласан ба тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын 2019 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг үндсэн нэгжүүдээс хянан хүлээн авч

баталгаажуулах, Сангийн Яамны төлөвлөлтийн нэгдсэн системд оруулах, шивэх ажлыг гүйцэтгэж, хуваарийг үндсэн нэгжүүдэд хүргүүлсэн ба цаг үеийн ажлын шаардлагаар үндсэн нэгж байгууллагуудын албан хүсэлтийн дагуу батлагдсан төсвийн хуваарийн сарын нийт дүн, бүлэг дотор нь төсвийн зардлын өөрчлөлтийг хийж, асуудлуудыг шийдвэрлэн ажилласан.

Дүүргийн орон нутгийн төсөвт байгууллагуудын 2019 оны төсвийн сар, улирлын хуваарийг хийж, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг даргаар батлуулан үндсэн нэгжид хүргүүлэн ажилласан ба тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын 2019 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг үндсэн нэгжүүдээс хянан хүлээн авч баталгаажуулах, Сангийн Яамны төлөвлөлтийн нэгдсэн системд оруулах, шивэх ажлыг гүйцэтгэж, хуваарийг үндсэн нэгжүүдэд хүргүүлсэн ба цаг үеийн ажлын шаардлагаар үндсэн нэгж байгууллагуудын албан хүсэлтийн дагуу батлагдсан төсвийн хуваарийн сарын нийт дүн, бүлэг дотор нь төсвийн зардлын өөрчлөлтийг хийж, асуудлуудыг шийдвэрлэн ажилласан.

Төрийн захиргаа, үйлчилгээний болон төрийн бус, олон нийтийн байгууллага, иргэдээс 9 өргөдөл, гомдол ирсэн ба үүнээс хугацаанд нь шийдвэрлэсэн 8, шийдвэр хүлээж байгаа өргөдөл, гомдол 1 байна.

Хэлтсийн хэмжээнд нийт 354 албан бичиг ирснээс хариутай 143, хариугүй 211 байгаагаас хугацаандаа шийдвэрлэсэн 331 албан бичиг, шийдвэрлэхээр хүлээж байгаа 21 албан бичиг, хугацаа хоцроосон 2, үүнээс: зөрчил тайлбартай гүйцэтгэсэн 4 албан бичиг тус тус гүйцэтгэл гарсан байна.

Батлагдсан төсвийн сарын хуваарийн дагуу орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын төсвийн санхүүжилтийн эрхийг үндсэн баримтаар нь хянан баталгаажуулах ажлыг гүйцэтгэлээ.

Өрхийн хөгжлийн дэмжих жилийн хүрээнд эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй үйлчилгээг хүргэх ажлын дэд хэсгийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч үзвэл 2019 оны 2 дүгээр улиралд 12 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээс 2019 оны 6-р сарын 14-ний өдрийн байдлаар 11 үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж, үзүүлэлт бүрийн гүйцэтгэлийн дундаж хувь 63,1%-тай гарч байна. Төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн тусад гаргаж, албажуулсан болно.

Дүүргийн Засаг даргын 2018 оны А/98 дугаар захирамжаар дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, “Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хороодын үйл ажиллагааг бүхий л талын дэмжлэг үзүүлэх зорилгоор Санхүү, төрийн сангийн хэлтсээс дүүргийн 17-р хороотой хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу эхний 5 сард хамтран зохион байгуулсан ажлын тайланг боловсруулан баталгаажуулж, цаасаар болон файлаар Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

**4. Дүүргийн өмч хөрөнгийн менежментийг сайжруулан, үр ашгийг нэмэгдүүлнэ.**

**4.1 Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн үзлэг тооллогыг хагас, бүтэн жилээр явуулж, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр дүүргийн хэмжээнд хийгдэж байгаа өмч хөрөнгийг бүртгэлд бүрэн хамруулна.**

**Хэрэгжилт, биелэлт:**



оруулалт, төсөл, хөтөлбөрөөр дүүргийн хэмжээнд хийгдэж байгаа өмч хөрөнгийг бүртгэлд бүрэн хамруулна.

**Хэрэгжилт, биелэлт:**

Дүүргийн нийтийн эзэмшлийн өмч хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, үр дүнг данс бүртгэл тусган, тооллогын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулан дүүргийн удирдлагуудад танилцуулан ажиллахын зэрэгцээ хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хийгдсэн хөрөнгийг данс бүртгэлд авах асуудлыг Н.Ө.Х.Г-т тавьж, зөвшөөрлийн дагуу бүрэн шийдвэрлэн ажиллаж, ашиглалтад нь бүртгэлээр хянал тавин ажиллаж байна.

**Хүрч буй үр дүн:** Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хийгдсэн хөрөнгийг заавар журмын дагуу данс бүртгэлд авах асуудлыг зохион байгуулж, ашиглалтад нь бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна.

**4.2 Орон нутгийн өмчийн байгууллагуудтай өмч эзэмшүүлэх гэрээг хийж, байгууллагын өмч хамгааллын байнгын комиссын ажлыг эрчимжүүлнэ.**

**Хэрэгжилт, биелэлт:**

Дүүргийн төсөвтэй харилцагч Орон нутгийн болон Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын өмч ашиглалтын 2018 оны гэрээг дүгнэх, 2019 оны гэрээг байгуулах ажлыг орон нутгийн 7, тусгай зориулалтын шилжүүлгийн 50, өрхийн эрүүл мэндийн төвийн 16, нийт 73 нэгжид зохион байгуулан гүйцэтгэж, гэрээг баталгаажуулан өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Хүрч буй үр дүн:** Орон нутгийн болон Тусгай зориулалтын төсөвт байгууллагуудын “Өмч ашиглалтын гэрээ”-г байгуулах, дүгнэх ажил хуулийн хугацаанд 100% хийгдэж, өмч ашиглалтад бүртгэлээр хяналт тавих ажил тогтмолжиж байна.

Танилцсан: Засаг даргын Тамгын  
газрын дарга А.Дамцагдорж

Санхүү, төрийн сангийн хэлтсийн  
дарга Ж.Орхонбаяр.

Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн  
хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан  
мэргэжилтэн Ш.Цэцэгмаа

Тайланг боловсруулсан: Санхүү, төрийн сангийн  
хэлтсийн мэргэжилтэн Л.Батзориг

*Л.Батзориг*  
2019.11.15